



ХҮНИЙ ЭРХИЙН ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГУУДЫН ФОРУМ

2020 оны 09 сарын 04 өдөр
хот

Дугаар 11

Улаанбаатар

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Г.ЗАНДАНШАТАР ТАНАА

Хүсэлт хүргүүлэх тухай

Монголын хүний эрхийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг ТББ-уудыг эгнээндээ нэгтгэсэн Хүний эрхийн форум нь коронавирусын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, иргэдийн амь нас, эрүүл мэндийг хамгаалах чиглэлээр Улсын Их Хурал, Засгийн газраас авч хэрэгжүүлж буй үйл ажиллагааг Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээнд заасан хүний эрхийн хэм хэмжээнд нийцэж буй эсэхэд байнга анхаарал хандуулж, шаардлагатай тохиолдолд санал, зөвлөмж өгч ирсэн билээ. Юуны түрүүнд Хүний эрхийн форумаас өгсөн санал зөвлөмжийг гамшгаас хамгаалах, цар тахалтай тэмцэх хууль тогтоомжид анхааран тусгасанд талархал дэвшүүлж байна.

УИХ-аас энэ оны 4-р сард баталсан Коронавируст халдварын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль хэрэгжээд даруй 5 сар болж буй бөгөөд тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.2, 6.3-т заасны дагуу УИХ-ын Түр хороо хуулийн биелэлтийг сар тутам нээлттэй хэлэлцэх үүрэг хүлээсэн билээ. Гэвч энэ хэлэлцүүлэг одоог хүртэл хийгдээгүйд Хүний эрхийн форум санаа зовиож буй бөгөөд Таныг тус хуулийн биелэлтийг хангуулж, хуулийн хэрэгжилтийн талаарх нээлттэй хэлэлцүүлгийг хуульд заасны дагуу яаралтай зохион байгуулахыг хүсч энэхүү захидлыг илгээж байна.

Хүний эрхийн форумын гишүүд